



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Есөнбулаг

Тээврийн хэрэгслийн техникийн  
хяналтын улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалт, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйл, "Авто тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн ерөнхий шаардлага" MNS4598:2020 стандарт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/199 тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, бүх төрлийн тээврийн хэрэгслийн 2024 оны татвар төвлөрүүлэлтийг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл зохион явуулсугай.

2. Техникийн хяналтын үзлэг явуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулах аймгийн комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт явуулах тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн хугацааг гуравдугаар, сумдад ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


3. Үзлэгийн хуваарь, бэлтгэл ажлын талаар тээврийн хэрэгсэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хэвлэл, радио болон албан бичгээр урьдчилан мэдээлэл өгч ажиллахыг аймгийн Авто тээврийн төв (С.Гантулга), аймгийн Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Сумын салбар комиссыг сумын Засаг дарга ахлан зохион байгуулж, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, татварын улсын байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, багийн Засаг дарга нарыг комиссын бүрэлдэхүүнд ажиллуулан, хавсралтад дурдсан хугацаанд авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт бэлэн байлгах ажлын явцын мэдээ тайланг холбогдох байгууллагуудад сар тутам мэдээлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Тээврийн хэрэгслийн татвар хураалтыг тогтоосон хувь хэмжээний дагуу хугацаанд нь хурааж төвлөрүүлэх ажлыг аймгийн Татварын хэлтэс (Н.Энхтуяа)-т үүрэг болгосугай.

6.2023 оны Техникийн хяналтын үзлэгт хугацаандаа хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг Авто тээврийн тухай хуулийн 17.2-т заасны дагуу замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны  
01 дугаар сарын 05 ны өдрийн 02 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

2024 оны тээврийн хэрэгслийн техникийн хяналтын  
үзлэг явуулах комиссын ажлын удирдамж

### **Техникийн хяналтын үзлэгийн зорилго**

Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, 2021 оны 12 дугаар 31-ний өдрийн А/199 дүгээр тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам, "Автотээврийн хэрэгсэлд тавигдах техникийн ерөнхий шаардлага" MNS4598:2020 стандартыг хангуулах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга дэг журам, соёлыг дээшлүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

### **Хяналтын үзлэг хийх бүрэлдэхүүнд орох байгууллагууд**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Автотээврийн төв, Цагдаагийн газар, Татварын хэлтэс хамтран хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэнэ.

### **Техникийн хяналтын үзлэг хийх үе шат, гүйцэтгэх ажил**

Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийг тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах;

Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчлөгч тээврийн хэрэгслийг бүртгэлийн нэгдсэн цахим шинэчлэн сүлжээнд оруулах;

Тээврийн хэрэгслийн судалгааг багын дарга нартай хамтран шинэчлэн тогтоох;

Эзэн холбогдогч нь тодорхой бус, сүүлийн 5 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслийг журмын дагуу хасалт хийх;

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын хураамж төлөгдсөн, жолоочийн албан журмын даатгалд хуулийн дагуу хамрагдсан, хяналтын үзлэгийн хураамж төлсөн баримтыг үндэслэн тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт хамруулж, тэнцсэн тээврийн хэрэгслийн гэрчилгээнд тухайн оны сар өдрийг тэмдэглэн бичилт хийж тэмдэг дарна;

Орон нутгийн нийтийн зорчигч тээвэр, нийтийн такси үйлчилгээний стандартыг мөрдүүлж ажиллах;

Сумуудад ажиллах үед техникийн хяналтын үзлэгт хамрагдах тээврийн хэрэгсэл зогсох зогсоолын зурвас татах, цахилгаан эрчим хүч, ажиллах, амрах байраар хангах, амралтын өдөр банк ажиллуулах;

Орон нутагт тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийн явц, байдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчлах стандартын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулан стандартын шаардлага хангуулах, тээврийн хэрэгслээ хяналтын үзлэгт хугацаанд нь хамруулаагүй иргэд, албан

байгууллагын удирдлагуудад нь шаардах хуудас, мэдэгдэл өгөх, хариуцлага тооцож ажиллах мөн тухайн сумд техникийн хяналтын үзлэг явуулахад бүртгэлтэй тээврийн хэрэгслийнхээ 75 хувиас доош хамрагдуулсан сумдыг Засаг даргатай нь хариуцлага тооцож давтан үзлэг зарлаж, өөрсдийн зардлаар нь дахин техникийн хяналтын үзлэг явуулна.

Тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийн ажлын дүн мэдээг сум, баг бүрээр тус тусад нь үнэлгээ өгч, 2024 оны нэгдсэн тайлан гаргаж аймгийн Засаг даргад танилцуулах техникийн хяналтын үзлэгийг хангалттай сайн зохион байгуулсан сумын ажлын хэсгийг урамшуулах, хангалтгүй ажилласан ажлын хэсэгт аймгийн Засаг даргын эрхийн хэмжээнд хариуцлага тооцно.

  oOo

Аймгийн Засаг даргын 2011 оны  
01 дугаар сарын 05-ны өдрийн 01 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг  
явуулах комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:	Г.Чинбат	(Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Н.Мэндбаяр	(Аймгийн Цагдаагийн газрын дарга)
	Н.Энхтуяа	(Аймгийн Татварын хэлтсийн дарга)
	А.Ержан	(Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа)
	Н.Алтанбагана	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын авотээврийн хяналтын улсын байцаагч)
	Д.Бат-Эрхэм	(Автотээврийн төвийн хяналтын улсын байцаагч)
	Л.Амгаланбаатар	(Автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер)
	Х.Бүрэнжаргал	(Татварын хэлтсийн бичил татвар хураалтын тасгийн дарга) (Сумдын Засаг дарга нар)
Нарийн бичгийн дарга:	С.Гантулга	(Автотээврийн төвийн дарга)

Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дугаар сарын 05 ны өдрийн 02 дугаар  
захирамжийн гуравдугаар хавсралт

Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт 2024 онд тээврийн хэрэгслийн  
техникийн хяналтын үзлэг явуулах хуваарь

№	Байгууллагын нэр	Авто машины тоо	Машины улсын дугаарууд	Хамрагдах хугацаа	Үзлэгт орсон эсэх
1	Иргэд		Жагсаалтаар	2024.01.23- 2024.03.01	
2	"Аяны зам-Алтай" ХХК		Жагсаалтаар		
3	"Тэгш-Алтай" ХХК	5	Жагсаалтаар	2024.03.02- 2024.03.08	
4	"Хишиг-Халиун" ХХК	8	Жагсаалтаар		
5	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	9	Жагсаалтаар		
6	"Мөнх жолоо" ХХК	15	Жагсаалтаар		
7	Батлан хамгаалах туслах нийгэмлэг	2	Жагсаалтаар		
8	"Ихэс-Алтай" ХХК	4	Жагсаалтаар		
9	Нэгдсэн эмнэлэг	12	Жагсаалтаар		
10	Малын удмын сан	1	Жагсаалтаар		
11	"Мандал-Алтай" ХХК	1	Жагсаалтаар	2024.03.09- 2024.03.15	
12	"Мандал голомт" ХХК	3	Жагсаалтаар		
13	"Мөрөн-Алтай" ХХК	1	Жагсаалтаар		
14	"Морьт баян" ХХК	1	Жагсаалтаар		
15	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК	2	Жагсаалтаар		
16	"Миний нутаг телевиз" ХХК	1	Жагсаалтаар		
17	"Алтай-Улиастайн ЭХС" ТӨХК	16	Жагсаалтаар		
18	"Тайшир-Гуулин" УЦС ХХК	3	Жагсаалтаар		
19	Цагдаагийн газар	21	Жагсаалтаар		
20	"Говь-Алтай АЗЗА" ХК	12	Жагсаалтаар		
21	"Тулга-Алтай" ХХК	8	Жагсаалтаар	2024.03.16- 2024.03.25	
22	Аймгийн Засаг даргын Тамгын газар	10	Жагсаалтаар		
23	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	жагсаалтаар		
24	Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар	4	жагсаалтаар		
25	"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ	19	Жагсаалтаар		
26	Шүүх	1	Жагсаалтаар		
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	2	Жагсаалтаар		
28	Тагнуулын хэлтэс	2	Жагсаалтаар		
29	Статистикийн хэлтэс	1	Жагсаалтаар		
30	Прокурорын газар	1	Жагсаалтаар		



31	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	9	Жагсаалтаар	2024.03.26- 2024.04.10
32	Боловсролын соёл, урлагийн газар	2	Жагсаалтаар	
33	Нийгмийн даатгалын хэлтэс	1	Жагсаалтаар	
34	Татварын хэлтэс	3	Жагсаалтаар	2024.04.10
35	Аудитын газар	2	Жагсаалтаар	
36	Гаалийн хороо	1	Жагсаалтаар	
37	Нийтийн Номын сан	1	Жагсаалтаар	
38	Шүүхийн шинжилгээний алба	1	Жагсаалтаар	
39	Нийгмийн үйлчилгээний халамжийн хэлтэс	3	Жагсаалтаар	
40	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс	1	Жагсаалтаар	
41	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба	4	Жагсаалтаар	
42	"Ус-Алтай" ХХК	3	Жагсаалтаар	
43	Хүнс, хөдөө аж ахуйн газар	5	Жагсаалтаар	
44	АШУҮИС-ийн салбар сургууль	4	Жагсаалтаар	2024.04.11- 2024.04.16
45	Эрүүл мэндийн газар	5		
46	Алтайн хүрд ХХК	4	Жагсаалтаар	
47	ХААН банк		Жагсаалтаар	
48	ХАС банк		Жагсаалтаар	
49	Төрийн банк		Жагсаалтаар	
50	МОНГОЛ банк	1	Жагсаалтаар	
51	Бүрэн дуулга-Алтай ХХК	2	Жагсаалтаар	
52	Бэлчээр ашиглалтын холбоо	1	Жагсаалтаар	
53	Улсын бүртгэлийн хэлтэс	1	Жагсаалтаар	
54	"Марал-Алтай" ХХК	1	Жагсаалтаар	
55	"Модончөлөө" ХХК	1	Жагсаалтаар	
56	Олон нийтийн Алтай радио	2	Жагсаалтаар	
57	"Цэргийн булаг" ХХК	1	Жагсаалтаар	
58	Автотээврийн төв	1	Жагсаалтаар	
59	Алтай чуулга	1	Жагсаалтаар	
60	Биеийн тамир спортын газар	3	Жагсаалтаар	
61	Сүм дундын Ойн анги	2	Жагсаалтаар	
62	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	1	Жагсаалтаар	
63	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	1	Жагсаалтаар	
64	Уламжлалт анагаах ухааны төв	1	Жагсаалтаар	

65	Улсын нөөцийн салбар	1	Жагсаалтаар	<div style="border: 2px solid red; padding: 5px; display: inline-block;"> <p style="color: red; margin: 0;">Хүндэтгэсэн</p> <p style="color: red; margin: 0;">2024.04.16</p> </div>
66	Шуудан үйлчилгээний газар	1	Жагсаалтаар	
67	Нийтлэг үйлчилгээ ОНТҮГ	4	Жагсаалтаар	
68	"Дуурсах-Алтай" ХХК	1	Жагсаалтаар	
69	"Мөнхтооройт" ХХК	9	Жагсаалтаар	
70	Нефть хангамжийн бааз	1	Жагсаалтаар	
71	Малын удмын сан	1	Жагсаалтаар	
72	"Залуур-Алтай" ХХК	1	Жагсаалтаар	
73	"Ентүм" ХХК	1	Жагсаалтаар	
74	"Гурванхулд" ХХК	1	Жагсаалтаар	
75	Орон нутгийг судлах музей	1	Жагсаалтаар	
76	Алтай Нисэх буудал	5	Жагсаалтаар	
77	"Атар-Арвай" ХХК	1	Жагсаалтаар	
78	Зоонозын өвчин судлалын төв	2	Жагсаалтаар	
79	"Мон-суль" ХХК	4	Жагсаалтаар	
80	"Аксу-Алтай" ХХК	1	Жагсаалтаар	
81	Эрүүл ус ОНӨААТҮГ	2	Жагсаалтаар	
82	"Айргийн хад" ХХК	4	Жагсаалтаар	
83	Онцгой байдлын газар		Жагсаалтаар	
<b>Нийт</b>			<b>277</b>	



**БАТЛАВ.**  
**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ**  
**ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН**  
**КОМИССЫН ДАРГА *Г.ЧИНБАТ***

Сумдын техникийн хяналтын үзлэг хийх бүрэлдэхүүн

Маршрут, үзлэг явуулах хугацаа

1 дүгээр чиглэл

№	Техникийн хяналтын үзлэг явуулах сум багийн нэр	Хугацаа	Хоорондын зай км	Аймгаас ажиллах бүрэлдэхүүн
1	Гуулин тосгон	2024.05.01	90	Автотээврийн төвийн үзлэгийн инженер -1, Автотээврийн хяналтын мэргэжилтэн, бүртгэлийн мэргэжилтэн -1
2	Дэлгэр сум	2024.05.02-04	30	
3	Чандмань сум	2024.05.06-08	150	
4	Эрдэнэ сум	2024.05.09-11	35	
5	Гэгээт баг	2024.05.13	45	
6	Баянтоорой тосгон	2024.05.14-15	170	
7	Зам хоног	2024.05.16	0	
8	Цогт сум	2024.05.17-19	90	
9	Бигэр сум	2024.05.21-23	87	
10	Наран баг	2024.05.24	55	
11	Алтай хотод ирэх	2024.05.24	110	

2 дугаар чиглэл

1	Рашаант баг	2024.05.27	45	Автотээврийн төвийн инженер-1, Хяналтын мэргэжилтэн -1, бүртгэлийн мэргэжилтэн -1
2	Шарга сум	2024.05.28-30	80	
2	Олонбулаг баг	2024.06.02	85	
3	Халиун сум	2024.06.03-04	50	
4	Цээл сум	2024.06.05-07	85	
5	Дэрстэй баг	2024.06.08	45	
6	Алтай сум	2024.06.10-12	200	
7	Зам хоног	2024.06.13	0	
8	Тахийн тал	2024.06.14	280	
9	Бугат сум	2024.06.15-17	30	
10	Төгрөг сум	2024.06.18-20	60	
11	Алтай хотод ирэх	2024.06.21	146	

3 дугаар чиглэл

1	Тонхил сум	2024.06.23.25	125	Автотээврийн төвийн үзлэгийн инженер -1, Хяналтын мэргэжилтэн-1, бүртгэлийн мэргэжилтэн -1
2	Дарив	2024.06.26-28	38	
3	Хөхморьт сум	2024.06.30-07.01	110	
4	Баян-Уул сум	2024.07.02-04	76	
5	Зам хоног	2024.07.05	78	
6	Жаргалан сум	2024.07.06-07	75	
7	Тайшир сум	2024.07.08-09	78	
8	Алтай хотод ирэх	2024.07.10	45	

4 дүгээр чиглэл

1	"Хан-Алтай" ХХК	2024.02 сард	90км	жагсаалтаар	Автотээврийн төвийн үзлэгийн инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн
2	"Алтайн хүдэр" ХХК	2024.09.12	220км	440	

\_оОо\_